

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

20... оны ... сарын-ны өдөр

№

Улаанбаатар хот

Зорчигч тээвэрлэлтийн гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г нэг талаас “.....” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал / цаашид (“Үйлчлүүлэгч” гэх), нөгөө талаас: МУ-ын иргэн, жолооч овогтой (регистрийн дугаар, цаашид “Тээвэрлэгч” гэх), /цаашид хамтад нь талууд гэх/ нар Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр тээвэрлэгч нь “.....” ХХК-ийн ажилчид /цаашид “зорчигч” гэх/-ыг **Улаанбаатар хот - Хөвсгөл аймгийн Хатгал сум – Улаанбаатар хот** чиглэлд аюулгүй тээвэрлэх үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд үзүүлэх, Үйлчлүүлэгч нь энэ гэрээнд заасан төлбөрийг тохирсон хугацаанд төлөхтэй холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2.
- 1.3. Тээвэрлэгч нь зорчигчдыг тухтай тээвэрлэх боломжтой, суудал багтаамж сайтай, техникийн бүрэн бүтэн байдал, мэргэшсэн жолооч бүхий өөрийн эзэмшлийн автобусаар үйлчилгээг үзүүлнэ.

ХОЁР. АЖЛЫН ХӨЛС, ХУГАЦАА

- 2.1. Зорчигч тээвэрлэх үйлчилгээг оны дугаар сарын-ны өдрийн ... цагт Улаанбаатар хот дахь үйлчлүүлэгчийн оффисоос эхлэн тээвэрлэх ба Хөвсгөл аймгийн Хатгал сумаас хийх буцах тээвэр нь оны дугаар сарын ...-ны өдрийн ... цагт эхэлж, Улаанбаатар дахь тээвэр эхэлсэн цэгт хүргэнэ.
- 2.2. Үйлчлүүлэгч нь тээвэрлэлтийн хөлсөнд төгрөгийг төлнө. Гэрээ баталгаажиж ажил эхлэхээс өмнө урьдчилгаа төгрөгийг, Тээвэрлэлтийг бүрэн дуусгасны дараа үлдэгдэл төгрөгийг тус тус төлнө.
- 2.3.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Үйлчлүүлэгчийг заасан хугацаанд, заасан газарт гэрээний дагуу аюулгүй тээвэрлэх үүрэгтэй. Хэрэв заасан хугацаанд тээвэрлэлтийг гүйцэтгээгүй, бүрэн бус тээврийн хэрэгслээр үйлчилсэн гэх мэт тохиолдлоос шалтгаалан үйлчлүүлэгч, зорчигч нарт учирсан эрүүл мэнд, эд хөрөнгийн хохиролыг тээвэрлэгч тал бүрэн хариуцна.
- 3.2.
- 3.3. Үйлчилгээ үзүүлэгчийн зорчигч тээврийн жолооч нь тээвэрлэлтийг эхлэхээс өмнө 8 цагаас доошгүй хугацаанд амарсан байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан жолоочоор тээвэрлэлтийг гүйцэтгүүлэхийг хориглох бөгөөд жолооч нь архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, буюу хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, үйлчилгээний үед автобусны зааланд тамхи татах, утсаар ярих, зорчих чиглэл, зааварчилгааг санаатай зөрчих, гадны хүн суулгах, зорчигчдыг тоог суудлын тооноос хэтрүүлж тээвэрлэх зэргийг хориглоно.
- 3.4.

Үргэлжлэл бий /Зх/